

Сургуулийн хотхон дахь буутай оюутан

Келли Ж. Асмуссен
Жонн В. Гресвелл

Энэхүү өгүүлэл нь анх 1995 онд Journal of Higher Education сэтгүүлийн 66-д хэвлэгдсэн ба миний бие John W. Creswell. Qualitative Inquiry and Research Design among Five Traditions (1998). Sage Publication бүтээлийн хавсралтад дахин хэвлэснээс авч орчуулсан юм. Хэдийгээр сургуулийн зүгээс сүүлийн 2 жилд хэвлэгдсэн бүтээлийг уншиж орчуулахыг даалгасан ч уг бүтээлийг сонгон орчуулах зайлшгүй шаардлага гараад байна. Энэ хичээлийн жилээс төгсөлтийн дараах сургалтад зааж буй Судалгааны арга зүй хичээлийн хөтөлбөр шинэчлэгдэж байна. Шинэчлэлийн хүрээнд бид чанарын судалгааны арга зүйд суралцуулахад анхаарсан бөгөөд энэхүү бүтээл чанарын судалгааны Кейс стади загварын сонгодог бүтээл болон үнэлэгддэг шилдэг өгүүллийн нэг юм. Иймээс уг хичээлд ашиглах үүднээс энэхүү өгүүллийг сонгон авч орчуулаад байна.

Энэхүү бүтээл нь чанарын судалгааны Кейс стади загварын дагуу судалгаа хэрхэн хийгдэж, үр дүнг хэрхэн өгүүлэл болгон бичих аргачлалд сургахад ихээхэн ач холбогдолтой. Уг судалгааны ажил нь хүчирхийллийн талаар баримтлах сургуулийн стратеги, сургууль дээр гарсан тохиолдлыг нарийвчлан судалж, сургууль дээр зэвсэг авч явдаг оюутнуудын асуудлыг хэрхэн шийдэх, аллагын үр дүн болох сэтгэл зүйн гэнэтийн цочролын талаар судлах зорилготой байв.

Өгүүллийн эхэнд сэдэвтэй төстэй судалгааны талаар товч дурдан оруулсаны зэрэгцээ уг судалгааны зорилгыг товч өгүүлсэн байв. “Үйл явдал ба хариулт” гэсэн дараагийн хэсэгт ямар тохиолдол, хаана, хэзээ, хэрхэн тохиолдсон тухай товч өгүүлжээ. Судалгааны ажил хэсэгт судалгааны ажлыг хэзээ эхэлсэн, ямар парадигма, логикийн аргад тулгуурласан, дүн шинжилгээг хэрхэн хийсэн, мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг ямар ямар эх сурвалжаас ямар ямар аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан зэргээр нарийвчлан тайлбарлан оруулсан байна. Энэхүү хэсгээс кейс стади-ийн дагуу хийгдсэн судалгаан ажлын ерөнхий загвартай танилцаж чадах юм.

Үүний дараах жижиг гарчиг бүхий хэсгүүд нь судалгааны үр дүнг танилцуулж буй хэсэг юм. уг судалгааны үр дүнг дараах сэдвүүдээр танилцуулсан байна. Эндээс чанарын судалгааны сэдэвчлэх, категоричлох гэдэг нь юу болох талаар суралцаж чадах юм. Хэнэггүй хандлага, айдас, хамгаалалт, дахин сэргээн хэлэлцэх нь, сургуулийн төлөвлөлт гэсэн сэдвүүдийн хүрээнд үр дүнг бичжээ. Энэ нь сургуулийн хотхонд буутай этгээд гарч ирэн хүчирхийлэл, түрэмгийллийн үйлдэл хийсний дараа ямар ямар харий үйлдлүүд гарч ирж байгааг харуулж байгаа юм.

Хэнэггүй хандлага гэсэн сэдвийн дор үйл явдал гарах үе болон гарсаны дараахан үеийн оюутнуудын хариу үйлдлийг ийн нэрлэж тайлбарлан бичсэн байна. Харин айдас сэдвийн доор сургуулийн хотхонд гарч буй айдсын талаар дүрслэн харуулжээ. Аливаа анги руу сургуулийн туслах ажилтны дараагаар ордог болсон тухай, сэтгэ зүйчид болон цагдаа нартай ярилцах, зөвлөгөө авах явдал өссөн тухай, гэмт этгээд батлан даалтаар суллагдаад дахин дайралт хийх эсэх тухай, тухайн хот оричмд ямар ямар гэмт хэрэг гарсан тухай мэдээллийг цацаж байгаа тухай зэрэг тэр орчинд айдас хүйдэс бүхий байдал хэд хоногийн турш үргэлжилсэн болохын өгүлсэн байна. Хамгаалалт сэдвийн дор сургуулийн хотхоны аюулгүй байдлыг хангахын тулд шинээр шинээр ямар бодлого гаргасан, ямар арга хэмжээнүүд авсан болохыг дүрслэн харуулжээ. Мөн дахин сэргээн хэлэлцэх сэдвийн дор хэсэг ухагцааны дараа тухайн үйл явдлыг мартаж байснаа дахин сэргээн санаж, хүмүүс дахин айдас хүйдэст орж, эсвэл хувийн аюулгүй байдалдаа анхаардаг, хэвлэл мэдээллээр ч дахин хэлэлцдэг тухай, сэтгэл зүйчдийн тайлбарын тухай өгүүлдэг. Харин сургуулийн төлөвлөлт хэсэгт авуулгүй байдлыг хангах төлөвлөгөө байдаг ч, онцгой гэнэтийн дэлбэрэлт, гал түймэр зэргээс хамгаалах тухай төлөвлөж байснаас биш буутай этгээд гарч ирээд түрэмгийлэл үйлдэх үед ямар арга хэмээ авах тухай сургуулийн бодлого байхгүй байна, ийм төлөвлөлтийг хэрхэн боловсруулж хийсэн тухай өгүүлдэг.

Сэдвүүдийг танилцуулсны дараагаар хэлэлцүүлэг хэсэгт сургуулийн хариу үйлдлүүдийг ниймийн янз бүрийн бүлгүүдээр задлан шинжлэх оролцдог хийсний зэрэгцээ энэ бүхэнд төр болон сургуулийн бодлого юунд анхаарах ёстой болохыг мөн дараа дараагаар уг судэвт холбогдох ямар ямар судалгааны ажил хийх шаардлагатай болох тухай өгүүлсэн байна.

Сургуулийн хотхон дахь буутай оюутан

Келли Ж. Асмуссен

Жонн В. Кресвелл

Сургууль дээр хүчирхийлэл гарах нь өсөж байгаа тухай, тэдгээрийг үйлдэгчдийн тухай өгүүлсэн номондоо зохиогч гэмт хэргийг арьс өнгө /12/ зэргээр ялгаж авч үзэлгүйгээр хүчин, жижиг танхайрал /9. 7. 8. 24/ зэрэг төрлөөр нь ялган авч үзсэн байгаа юм. Америкийн коллежийн ажилтнуудын холбоонд зориулан Роарк нар /24/ коллеж дээр гардаг биеийн, сэтгэл зүйн, бэлгийн хүчирхийлэлийн хэлбэрүүдийн талаар судалж тэдгээрээс урьдчилан сэргийлэх удирдамжийг боловсруулсан байна. Мөн Роарк /23/ ахлах сургуулийн сурагчид нь өөрсдийн хийхээр завдсан хүчирхийлэлийн түвшингээ тогтооход ашиглаж болох шалгуурыг санал болгосон байна. 1989 оны арван нэгдүгээр сард ерөнхийлөгч Буш “сурагчдын суралцах эрх ба сургуулийн аюулгүй байдлын тухай хууль”-д гарын үсэг зурснаар үндэсний хэмжээнд хэрэглэгдэх эрх зүйн актыг тогтоосон байна. Тус актад сургууль, коллеж, их сургуулиуд нь оюутнууд, ажилчид, суралцахаар хүсэгчдэд сургуулийн аюулгүй байдлын тухай хийгээд гарсан гэмт хэргийн статистик мэдээллийг тайлагнаж байхыг заасан байна /13/.

Сургуулийг хүчирхийллийн төлөв байдалд оруулж буй нэг хэлбэр бол оюутан буу гарган сүрдүүлэн халдах явдал юм. Сургууль дээр гарсан гэмт хэргийн тайлангуудаас харахад тэнд хулгай дээрмээс эхлээд бусдын эрүүл мэндэд халдах, хүн амины эсрэг гэмт хэрэг гарах нь өсөж байгааг харуулж байна /13/. Айовагийн ИС /16/, Флоридагийн ИС /13/, Монреал дахь Консордиагийн ИС, Монтроеалийн. Политехникийн ИС-иуд /22/ дээр гарсан аллагууд нь шоконд оруулсан. Иймэрхүү үйл явдлууд нь сэтгэл зүйн гэнэтийн цочролд оруулж, сургуулийн аюулгүй байдал, сургуулийн амьдралын хэвийн төлөв байдлыг алдагдуулж хойноосоо маш их шүүмжлэлийг дагуулдаг. Уг үйл явдлын талаар сонин хэвлэлд бичдэгээс гадна дунд сургуулийн судалгаанд бичдэг ба гэвч иймэрхүү таагүй үйл явдлын дараагаар сургууль чухам юу хийдэг тухайд анхааралгүйгээр өнгөрсөн байдаг. Иймээс тэднийг илүү ойлгох үүднээс хэн нэгэн сургууль дээрх буу хэрэглэсэн хүчирхийлэлийн талаар эргэн судлах нь зүйтэй юм. Уг судалгааны ажил нь түрэмгийлэлийн /21. 23/ талаар баримтлах сургуулийн стратеги, сургууль дээр гарсан тохиолдлыг судлах /6. 14. 15/ сургууль дээр зэвсэг авч явдаг оюутнуудын асуудлыг хэрхэн шийдэх /1/, аллагын үр дүн болох сэтгэл зүйн гэнэтийн цочролын талаар судлахад чиглэх юм /32/.

Сургуулийн стратеги, протоколуудаас хүчирхийлэлийн дараах сургуулийн хариу арга хэмжээг судлах хэрэгцээ шаардлага, судалгааны үзэл баримтлалын загварыг тодорхойлсон байна. Бидэнд иймэрхүү үйл явдалд нөлөөлөл үзүүлсэн болон тэр үйл явдалд оролцсон хүмүүсийн бүрэлдэхүүнтэй холбогдох зохион байгуулалтын асуудал хийгээд сэтгэл зүйн талаас нь хэмжин судалж ойлгох нь илүү чухал байсан юм. Үйл явдлын контекстийг илрүүлэхэд чиглэсэн гүнзгийрүүлсэн чанарын кейс судалгаа нь онолын үзэл баримтлалын болон прагматик ойлголтоосоо татгалзсан байхыг чухалчилдаг. Уг судалгааны өгүүлэл нь чанарын кейс судалгааг /31/ харуулсан ба тэр нь буу хэрэглэсэн гэмт явдал дахь сургуулийн хариу арга хэмжээг ойлгож тодорхойлсон юм. Бид Чухам юу тохиолдов?, энэ үйл явдалд хэн хариу арга хэмжээ авав?, энэ үйлдлын дараах 8 сарын туршид ямар ямар

хариу арга хэмжээнүүд авагдав?, энэхүү сургуулийн хариу үйлдлийг ойлгоход ямар онолын байгууламж тусалж болох вэ?, энэ тохиолдлын онцгой өвөрмөц зүйл нь юу байсан бэ? гэсэн асуултуудын хариултыг олоход чиглэсэн юм.

Үйл явдал ба хариулт

Мидвестерн хотын томоохон их сургуулийн хотхонд нэгэн үйл явдал болсон. Арван жилийн өмнө уг хот нь “бүх-Америкийн хот” гэж нэрлэгдэж байсан. Гэвч одоо аллага болон зодоон танхайрлын гэмт хэргийн тоон өсөлт хэвийн тархалттай, тайван амар амгалан хот юм байна. Хүчирхийлэлийн шинжтэй гэмт хэргүүдийн заримд нь их сургуулийн оюутнууд оролцсон байв. Судалгаа хийгдсэн гэмт үйл явдал нь арван сарын нэгэн Даваа гаригт тохиолдсон юм. 43 настай Төгсөлтийн дараах сургалтын оюутан Солонгосын дайны хагас автомат винтов, 30-н калибрын бууг гартаа барьсаар хичээл эхлэхээс цөөн минутын өмнө ангид орж ирсэн байна. 34 оюутнаас 20 нь ангидаа ирсэн байсан ба тэдгээрийн ихэнх нь чимээгүйхэн оюутны сонингоо уншиж байсан байна. Харин багш анги руу орохоор чиглээд явж байв.

Нөгөөх буутай эр винтовоо оюутнууд руу чиглүүлэн өрөө рүү хөндлөн далайж, гохыг дарсан байна. Гэтэл буу гэв гэнэт зогссон байна. Тэрээр гацааг нь зогсоох гэж багшийн ширээн дээр цохиж, буцаад маш түргэн хугацаанд галлаж эхэлсэн байна. Ахиад л гал зогссон байна. Энэ үед л ихэнх оюутнууд чухам юу болоод байгааг ухаарч ширээнүүдээ түлхэн унагааж өөрсдийгөө хаахаар оролдож эхэлсэн. Ойролцоогоор 20 орчим минутын дараагаар нэг оюутан нөгөө буутай хүн лүү ширээг түлхсэн ба бусад оюутнууд нь түүний хажуугаар сургуулийн коридор луу гарч улмаар уг байшингаас гарцгаасан байна. Буутай эр яаран өрөөнөөс гарч, тус байшингаас машины зогсоол руу гүйн явж одсон ажээ. Түүнийг цагдаагийнхан 1 цагийн дотор түүний амьдардаг хажуугийн жижиг хотоос барьж авсан байна. Хэдийгээр тэрээр тэр үед хорих байранд хоригдож, шүүх ажиллагаагаа хүлээж байсан ч түүний энэхүү үйлдлийн сэдлийг хэн ч мэдэж чадаагүй юм.

Сургуулийн цагдаа болон сургуулийн удирдах ажилтангууд болсон үйл явдалтай холбогдуулан анхны арга хамжээг авсан. Утсаар тэдэн лүү тусламж хүссэний дараагаар 3 минутын дотор сургуулийн цагдаа хүрч ирсэн. Тэд түгшүүртэй байсан хэдэн минутын турш байшингийн гаднаас зандалчинг хэн болохыг нь тогтоохын тулд оюутнуудтай ярилцсан. Харин сургуулийн удирдлага уг үйл явдлаас 4 цагийн дараагаар өдрийн 4 цагт хэвлэлийн бага хурал зарлаж хийлгэсэн байна. Цагдаагийн дарга, оюутны асуудал эрхэлсэн албын дэд дарга, 2 оюутны хамтаар болсон явдлын талаар хэвлэлийн бага хурал дээр мэдээлэл хийжээ. Үдээс хойш нь Оюутны алба Оюутны эрүүл мэндийн хийгээд ажил эрхлэлтийн талаар зөвлөх хөтөлбөртэй холбоо тогтоон, туслуулахыг хүссэн ямар ч оюутан, ажилтанд туслалцаа үзүүлэхийг даалгасан байна. Оюутны алба хичээлийн хэвийн байдлыг хангах үүднээс шинэ ангийг эмхэлж янзалсан. Хуулийн алба их сургуулиас зандалчинг хөөсөн ажээ. Дараагийн өдөр нь сургуулийн удирдлага ээлжит хурлаараа уг үйл явдлыг авч хэлэлцсэн байна. 7 хоногийн туршид оюутны алба цөөн тооны оюутан, багш ажилтан нараас оюутны дэг журам зөрчсөн үйлдэл, оюутнуудад энэ үйл явдал нь тархаж байгаа тухай дуудлага хүлээн авсан байна. Ажил эрхлэлтийн талаар зөвлөх хөтөлбөрийн зөвлөх сэтгэл судлаачтай сэтгэл зүйн гэнэтийн цочрол, боловсролын хямралын талаар зөвлөлдсөн ажээ. Зөвхөн нэг оюутан л оюутны эрүүл мэндийн зөвлөхөд

хандсан байна. Сургуулийн болон орон нутгийн сонингууд болсон үйл явдлын талаар үргэлжлүүлэн бичигдэж байв.

Халдлагад өртсөн ангийн хичээл 2-4 өдрийн дараагаар хуваарийн дагуу хичээллэж эхэлсэн ба оюутнууд, мөн багш нар орон нутгийн 2 хуульч, цагдаагийн дарга дээр очсон байна. Мөн 2 оюутан сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр ярилцах сургалт явуулж байсан зөвлөхөд хандсан байна. Энэ нь оюутнуудад хууль эрх зүйн талаар мэдээлж, оюутан багш нар бие биендээ тус үйл явдлын үеэр юу мэдэрсэн, энэ талаар ямар туршлагатай болсон талаар өөр хооронд нь ярилцуулахад анхаарч байсан юм. Уг явдал болсноос хойш 1 долоо хоногийн дараа нөгөө ангийн оюутнууд урьдын адил төлөв байдалдаа эргэн орсон байна. Энэ үеэр хүчирхийлэлийн талаар ерөнхийд нь анхаарлаа хандуулж байсан цөөн тооны эмэгтэй оюутнууд оюутны эрүүл мэндийн төвийн зөвлөхүүдтэй уулзаж байсан байна. Тэдгээр зөвлөх нар тус зөвлөх үйл ажиллагаа, сургуулийн аюулгүй байдлын талаар сонирхон асууж байсан хэдэн арван эцэг эхчүүдээс асуулт асууж байв. Зарим эцэг эхчүүд сургуулийн удирдлагуудаас хамгаалалтын үйл явцын талаар утсаар лавлаж байв.

Болсон явдлын даарх 7 хоногийн туршид сургуулийн сонинд сэтгэл зүйн гүнзгий цочрол орсны айдас болон сэтгэл зүйн цочролын талаар хэд хэдэн өгүүлэл бичигдэж байв. Сургуулийн удирдлага сургуулийн удирдах зөвлөлд болсон үйл явдлыг өгүүлсэн баримтууд бүхий захидлыг илгээсэн байна. Захиргааныхан сургуулийн ажилтан, оюутан нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай мэдээлсэн. Эцэст нь нэгэн коллежийн декан ажилтан нартаа “оюутны ухаан балартах зан үйл”-ын тухай өгүүлсэн тэмдэглэлээ илгээсэн бол нэгэн тэнхмийн эрхлэгч сургуулийн ажилтан, зөвлөгч нартай хамт оюутны “ухаан балартах” зан үйлийн талаар ярилцах боловсролын бүлгэмийн хичээлийг зохион байгуулахыг хүсэж улмаар зохион байгуулсан байна.

Янз бүрийн ажилтны бүлгэмүүд ажил эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх хөтөлбөр дээр сургуулийн багш, ажилтан нарт зориулан зөвлөгөө өгөх хөтөлбөрийг хэдэн 7 хоногийн туршид хэрэгжүүлэхийг хичээж байв. Эхний бүлгэм нь тэрхүү гэмт үйл явдлын үед байсан, тэр үйл явдалд биеэр оролцсон хүмүүсийг багтааж байсан ба хамгаалалтын мэргэжлийн туслалцаа үзүүлэх тухайд анхаарч байсан. Мөн сэтгэл зүйн цочролыг биеэр амссан хүмүүст голлон анхаарч байлаа. 2 дахь бүлгэм нь сэтгэл зүйн цочрол нь гарсан, уг үйл явдалтай дам байдлаар холбогдсон хүмүүсийг анхаарч байв. Энэхүү бүлгэм нь тэдгээрийн айдас нь зандалчингийн хийсэн үйлдлээс болсон гээд айдас нь хүчтэй болох үеэс өмнөх үеийн айдсын тухай ярицлахыг тэд хүсэж байсан. Гурав дахь бүлгэм нь сэтгэл зүйн гүнзгий цочролд өмнө нь орж байсан туршлагатай ажилтнууд багтаж байсан ба болсон үйл явдал нь тэдгээрийн айдсыг нь дахин сэргээсэн хэрэг байв. Хэдэн ажилтан нар Ажил эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх хөтөлбөрийн хүрээний нэг сарын туршид ажиглалтад байсан боловч стресс нь хожигдож илэрсэн тухай буюу шинэ бүлгэмийн тухайд бичигдээгүй байна. Ажил эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх хөтөлбөрийн зөвлөх эдгээр бүлгэм бүрийн хариу үйлдэл нь хэвийн байдлаар хариулж байсан гэж тэмдэглэжээ. Сарын дотор хэдийгээр болсон үйл явдлын талаар олон нийтээр хэлэлцэх нь буурч АЭТЗӨХөтөлбөрийн ба Оюутны эрүүл мэндийн зөвлөгчид одоо болон ирээдүй дэх ямар ч хүчирхийлэлийн талаарх сургуулийн төлөвлөгөөг зохион байгуулж зохицуулах хэрэгтэйг илэрхийлж эхэлсэн байна.

Судалгааны ажил

Бид судалгааны ажлаа уг үйл явдлаас хойш 2 өдрийн дараагаар эхэлсэн. Бидний судалгааны эхний алхам бол их сургуулийн захиргаа, эрдмийн зөвлөлөөс зөвшөөрөл авахын тулд судалгааны протоколын нооргийг боловсруулах явдал байв. Бид зандалчинг илрүүлэх, зөвлөгчдөөс зөвлөгөө авч буй ажилтан, оюутнуудын засал эмчилгээний талаар судалгаанд оруулахгүй гэдгээ тодорхой өгүүлсэн. Мөн бид сургуульд багтдаг бүлгүүдийн хариу үйлдлийг л сонирхон судална хэмээн судалгаагаа хязгаарласан. Энэхүү зааг хязгаар нь буутай зандалчингийн үйл явдалд үзүүлэх сургуулийн хариу үйлдлийг өндөр түвшинд хувьсах хэмжигдэхүүнүүд нь хэмжих боломжгүй тул чанарын судалгааны кейс стади судалгааны дагуу судалгаагаа явуулахаар тогтсон юм. Конструктивист уламжлал ёсоор судалгааны загварын талаар парадигмын төсөөлөлтэйгээр эхэлсэн энэхүү судалгаа нь задлан шинжлэх индуктив логик, судлан шинжлэх ажил нь тухайн контекстээс хамааран явагддаг загвар юм /10/. Бид бас судалгаагаа цаг хугацаагаар /8 сар/, зөвхөн нэг тохиолдлыг л /сургуулийн хамт олонг/ судлахаар л хязгаарласан. Хожим нь бид ярилцлагадаа сургуулийн өөр олон тооны мэдээлэл өгөгчдөөр хүрээгээ өргөтгөж, дараах 5 асуултыг багтаасан хагас стандартчлагдсан ярилцлагыг хийсэн. Болсон үйл явдлын үеэр та ямар үүрэг гүйцэтгэсэн бэ?, таны оролцсон энэхүү үйл явдлын дараагаар танд юу тохиолдсон бэ?, энэхүү үйл явдал нь сургуулийн хамт олонд ямар нөлөө үзүүлсэн бэ?, энэхүү үйл явдлаас болж чухам юу илүүтэйгээр олон салаа болон өргөжсөн бэ?, бид хэнтэй ярилцвал энэ үйлдэлд үзүүлэх сургуулийн хариу арга хэмжээнүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авч чадах вэ? Бид мөн ажиглалтын мэдээлэл, баримт бичиг зэрэг бусад материалуудыг цуглуулсан /мэдээлэл, эх сурвалжийн хэв маягуудын талаар өгүүлсэн хүснэгт 1-ийг харна уу/.

Өгүүлэлийн бүтэц нь нарийвчлагдсан, мэдээлэл өгөгчдийн хэлсэн ярианаас ишлэл татан өөрсдийн тайлбарлалыг баяжуулж, өөрсдийн тайлбарлалаа зохион байгуулалтын хийгээд сэтгэл зүйн асуудлын хүрээгээр хязгаарлан бичигдсэн байна. Мэдээлэл өгөгчдөөс цуглуулсан тохиолдлуудын эхний нооргийг гарган тайлбарлал, тодорхойлолтоо эргэн харж, дараа нь төгсгөлийн судалгаанд тэдгээрийн саналыг оруулах замаар шалгаж байсан /17. 18/. Бид өөрсдийн анхны тодорхойлолтоо шалгахдаа болсон үйл явдлын талаар болон хүмүүсийн хариу арга хэмжээнүүдийн талаарх бидний ойлголт нь зөв байна уу?, бидний гаргасан хувилбар, задлан шинжилсэн явдал маань таны туршлагатай холбоотой байна уу?, ийм тохиолдлуудтай та таарч байв уу?, сургуулийн төлөвлөгөө хэрэгтэй юу?, тэр нь ямар хэлбэртэй байвал зохилтой вэ гэсэн асуултуудыг асуух замаар бүлгийн ярилцлагын үед шалгаж байв.

Хүснэгт 1. Мэдээлэл цуглуулах матриц: мэдээллийн эх сурвалжийн хэв маягууд

Мэдээлэл/эх сурвалж	Ярилцлага	Ажиглалт	Баримт бичиг	Аудио бичлэгийн материал
Үйл явдалд оролцсон оюутнууд	Тийм		Тийм	
Бусад	Тийм			

оюутнууд				
Төвийн удирдлага	Тийм		Тийм	
Сургуулийн цагдаа	Тийм	Тийм		
Багш нар	Тийм	Тийм	Тийм	
Ажилтан нар	Тийм			
Физикал плант		Тийм	Тийм	
Сурвалжлагч, ТВ, өгүүлэл	Тийм		Тийм	Тийм
Оюутны эрүүл мэндийн зөвлөх	Тийм			
Ажил эрхлэлтийн талаар зөвлөгөө өгөх хөтөлбөрийн зөвлөх	Тийм			
Сэтгэл зүйн огцом цочролын мэргэжилтэн	Тийм		Тийм	Тийм
Сургуулийн бизнесменүүд			Тийм	
Удирдах зөвлөлийн гишүүд			Тийм	

Сэдвүүд

Үгүйсгэл

Хэдэн 7 хоног өнгөрсний дараа бид тус үйл явдал болсон түлхэн унагаасан ширээний оронд хичээллэхэд тохирсон, лекц болон хэлэлцүүлэг хийхэд бэлтгэгдсэн өрөөнд очсон юм. Өрөөний гаднах коридор нь маш нарийн байсан ба бид тэр өдөр оюутнууд яаж тийм богино хугацаанд буутай эрд мэдэгдэлгүйгээр байшингаас гарсан болохыг төсөөлөн бодсон. Мөн тэрхүү үйл явдлын үеэр тэр коридорт байсан олон оюутнууд байшинд буутай хүн байна гэдгийг сонсож, харах хүрэтлээ түүнийг мэдээгүй байсан. Егөөтэйгээр бодож үзвэл тэдгээр оюутнууд тэрхүү аюултай нөхцөл байдлыг үл анзаарч тоохгүй байсан байна. Илүү найдвартай хамгаалалттай газар болох далд газар нуугдаж байхаасаа илүү тэд хамтдаа олноороо бужигналдан гадагшаа гарахаар зүтгэцгээсэн байна. Оюутнуудын нэг нь ч анги дотор өөрсдийгөө хамгаалаагүй ба буутай зандалчин эрээс зайтай хамгаалалттай газраасаа гарч явцгаасан байгаа юм. “Хүмүүс өөрсдөө тойрог үүсгэн бие биендээ наалдан зогсохыг хүсэж байсан” гэж сургуулийн цагдаагийн офицер хэлэв. Ангид байсан

оюутнууд хамтдаа байшингаас бужигналдан гарах үеийн хамгийн аюултай нөхцөлд оюутнууд цухалдан бухимдсан байдлаар ярилцацгааж ямар нэг үйлдэл үзүүлж чадаагүй байна. Харин цөөхөн тооны оюутнууд л сэтгэл хөдлөлөө ил гарган хашгирч байсан байна. Тэдгээрийн зан төлөвийн талаар асуухад нэг оюутан “бидний ихэнх нь яг хүүхэд аятай байсан” гэж хэлсэн байна. Тэдгээрийн үг яриа нь тэдний хэн нь ч жинхэнэ аюултай нөхцөлд ороогүй, энэ үйл явдал нь жирийн нэг зүйл байсан гэж үл тоомсорлон, бусдад итгүүлэхэд чиглэж байв. Сургуулийн цагдаагийн офицер мөрдөн байцаалтынхаа явцад оюутнуудын гаргасан зан үйлийг маш ихээр гайхсан байна:

Иймэрхүү үйл явдал болсоны дараагаар хүмүүс харахаар тойрог болоод зогсох нь онцгой гйод сонин зүйл биш. Америк хүмүүс нь ямар нэг үйл явдлыг харах гэсэн сониуч зантай хүмүүс. Муу зүйл тохиолдсны дараагаар хүмүүс тойрон ажигладгийн учир нь энэ юм. Тэд жинхэнэ аюултай нөхцөл байдалд өөрсдөө байсныгаа хараагүй бөгөөд ойлгож чаддаггүй ба тэд шархдан гэмтэх хүртлээ тэндээс явах дургүй байдаг.

Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөх анхны хариу үйлдэл нь сюрреалистик хариу үйлдэл байсан хэмээн тодорхойлолтоо нотолсон. Зөвлөхийн энэ үгийг нарийвчлан нэгэн эмэгтэй оюутан “зандалчин алж орхино шүү гээд жижиг тугны тэндээс буудах байх гэж бодож байсан” гэж ярьсан. Түүний хувьд уг үйл явдал нь бараг мөрөөдөл аятай байсан байна. Ийм уур амьсгал байснаас уг ангиас нэг ч оюутан уг үйл явдал болсны дараах 24 цагийн алинд ч сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөх рүү хэдийгээр ийм үйлчилгээ байдгийг бүгд мэддэг атлаа нэг нь ч утастаж хандаагүй байна. Харин ингэхийн оронд оюутнууд найз нартаа юу болсон тухай ярьж, бааранд орцгоосон бөгөөд харин хожим нь уг үйлдлийн хэцүү байдал нь санаанд нь орж ирсэн байна. Нэг оюутан уг үйл явдал болсны орой нь ТВ-р болсон явдлын талаар мэдээлсний дараагаар л айж, мөн уур нь хүрч цухалдаж байгаагаа мэдэрсэн байна.

Зарим эцэг эхчүүд зөвлөх рүү хандсан бөгөөд тэдний ярианаас оюутнууд нь болсон үйл явдлыг аюулгүй хэмээн няцааж байж болзошгүй болохыг баталсан байна. Нэгэн оюутан миний эцэг эх зааж зөвлөх дуртай, “Би чамайг иймэрхүү зүйлд орооцолдсонд ер гайхахгүй байна, чи үргэлж иймэрхүү зүйллтэй өөрийгөө хутгаж явдаг” буюу “Чамд золоор муу зүйл тохиолдсонгүй, энэ бол аймаар зүйл байсан, бушуухан л хэвтэж бай” гэж зөвлөсөн гэж хэлсэн байна. Харин нэг оюутан болсон явдлын талаар ээж нь тоохгүй байсанд маш их уур нь хүрч цочролд орсон байна. Тэрээр хэн нэгэн хүн түүнтэй зэрэгцэн сууж болсон явдлын талаар сонсож түүнд итгэхийг хүссэн байгаа юм.

Айдас

Бид ангид очих үедээ айдас хэмээх 2 дахь сэдвээ олж авсан юм. Уг үйл явдал болсны дараа уг ангийн хаалган дээр өөр байшинд нүүж очсон тухай зарыг олж харсан юм. Мөн тэдгээр нь оюутнууд нь нарийн бичгийн даргын хамтаар зэргэлдээ анги танхимыг нь шалгаж байж ордог болсон тухай зараас харсан юм. Болсон явдлаас 2 өдрийн дараагаар сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө өгөх төвийн 2 оюутан, сургуулийн цагдаагийн хэсгийн дарга, орон нутгийн 2 хуульч, оюутнуудтай тэдгээрийн айдас, реакци, бодол санаа зэргийн талаар ярилцсан байна. Айдсын хариу үйлдэл нь эхний ярилцлагын үеэр гадна талаас ахжиглагдахуйц болж ирсэн ба 2 дахь уулзалтын үеэр ч илэрсэн байна.

Удалгүйхэн ихэнх оюутнуудын айдас нь буруутан этгээдийг батлан даалтад гаргах үндэслэл хайж байгаа юм биш биз гэсэн бодолтой нь холбогдож байв. Оюутнууд буруутан этгээд шоронд хоригдож байгаагийнхаа бурууг оюутнуудад тохон, хэрэв батлан даалтаар гарвал өшөөгөө авах гэж оролдох байх гэж бодож байв. Нэг оюутан “би ангид буцаж орж ирэх үедээ маш их айж байна. Тэд ангийг өөр газарт өөрчилж болно, гэвч биднийг тэр этгээд олохоос бүрэн зайлуулж өгч байгаа хэрэг биш” гэж хэлсэн байна. Эхний ярилцлага дээр сургуулийн цагдаагийн хэсгийн дарга шүүх буруутан этгээдийг батлан даалтад гаргахаас татгалзаж байгаа гэдгийг мэдэгдсэнээр айдсыг бууруулж, сарниулж чадсан байна. Энэхүү мэдэгдэл нь зарим оюутнуудыг өөрсдийн аюулгүй байдалд эргэлзэж байсныг нь арилгахад тус болсон байна. Сургуулийн цагдаагийн хэсгийн дарга оюутнууд зандалчингийн байгаа байдлын талаар бусдад мэдээлэх нь чухал гэж бодсон байна. Учир нь зарим оюутнууд хэрэв зандалчин суллагдвал өөрсдийн аюулгүй байдалдаа санаа зовж байна хэмээн утастсан юм байна.

2 дахь ярилцлагын үеэр өөр нэг айдас илрэн гарсан байна. Өөр нэг этгээд тэдэн лүү ангид байх үед нь дайрч болзошгүй гэсэн айдас байв. Нэгэн оюутан аюул занал гарч болзошгүй гэсэн байдлаар хандаж байсан ба зөвлөхийн зөвлөснөөр 10 сарын үйл явдлаас хойшид бүх өрөөнүүдийг шалгасныхаа дараа анги руу ордог болсон байна. Энэ ярилцлагын үеэр оюутнууд уурлаж бухимдаж, түрэмгий зан байдалтай болж байгаагаа мэдэрсэн ба эцэст нь тэд өөрсдийгөө аюулгүй байдалгүй байна гэдгээ хүлээн зөвшөөрч эхэлсэн байна. Нэг эмэгтэй оюутан л сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээг үнэлсэн ба энэхүү мэдэгдэл нь ямар ч оюутан зөвлөгөөг чөлөөтэйгээр авч чаддаг байдалд хүргэсэн байна.

Энэ үед тухайн хотод хүчирхийлэлийни гэмт хэргийн тоо өссөн нь оюутнуудын айдсын улам бүр ил болгосон байна. Буутай дайралтын өмнөхөн 3 залуу эмэгтэй нэг эрэгтэйгийн хамтаар хүүхэд хулгайлаад хожим нь хүүхдийн цогцос хажуугийн хотоос олдсон юм байна. Их сургуулийн хөлбөмбөгийн тамирчин нэгэн эмэгтэйг маш чангаар цохиж унагаасан байна. Тэрээр дараа нь энэ үйлдлээ дахин давтаж, цагдаатай зодолдсон юм байна. Буут халдлагаас 3 7 хоногийн өмнө их сургуулийн нэгэн эмэгтэй оюутан нэгэн эхнэр хүүхдийг хулгайлан, маш хэрцгийгээр алсан байжээ. Иймэрхүү хэд хэдэн аллага энэ хотод гарсан байв. Оюутны сурвалжлагч энэ улирал бүхэлдээ хүчирхийлэлдийн шинжтэй байлаа хэмээн цохон тэмдэглэсэн байна.

Хамгаалалт

Хотод гарсан хэд хэдэн гэмт хэрэгт их сургуулийн оюутнууд оролцож, түүний дараагаар сургуулийн танхимд буутай этгээд үймээн тарьсан нь сургуулийн амгалан тайван байдлыг бүрэн алдагдуулсан юм. Оюутнууд ангиас гарах үед маш эмх замбараагүй байдал /хаос/ байдал үүссэн, энэ нь маш санамсаргүй үзэгдэл байсан, тэдгээр оюутнуудын өөрийгөө хамгаалах мэдрэмжийг хэн нэгэн хулгайлаад аваад явсан юм шиг л болсон гэж бүх болсон юмсыг нэгэн зөвлөх илэрхийлсэн. Ийнхүү олонхи мэдээлэл өгөгчдийн хувьд хамгаалалтын асуудал нэгэн сэдэв байсан юм.

Оюутны асуудал эрхэлсэн албаны дарга болсон үйл явдалд үзүүлж бөуй захиргааныхны хариу үйлөдлийг тодорхой харуулсан ба оюутнуудын анги танхим дахь аюулгүй байдлыг хангах нь бидний анхдагч зорилго, сэтгэл зүйн стрессэд орсон оюутнуудад туслах тухай мэдээллийн хэрэгслээр түгээх хэрэгцээ байгаа ба ингэснээр мэдээллийн хэрэгсэл нь оюутны аюулгүй байдлыг хангах туйха үргэлжлүүлэн мэдээлэх юм. Аюулгүй байдал, мөн зэвсэг бүхий этгээд халдаж болзошгүй тухай ярихдаа тэрээр оюутнууд руу халдаж болзошгүй буутай этгээдийг хорьж цагдаа ажлыг цагдаагийн байгууллага хийж байгаа тухай дурьдсан. Болсон явдлын дараах 4 цагийн дотор уг үйл явдлын талаар товч мэдээлэлэхээс илүү дэлгэрнгүй нарийвчлан мэдээлэхийг чухалчилж, сургуулийн. Аюулгүй байдлын баталгааг гаргахыг шаардан хэвлэлийн бага хурлыг хэвлэлийнхэн хийлгэсэн байна. Удалгүйхэн сургуулийн захиргааныхан хэвлэлийн компанид аюулгүй байдлынхаа тухай мэдээлсэн. Болсон үйл явдлыг тодорхойлон бичсэн захидлыг удирдах зөвлөлд явуулсан /удирдах зөвлөлийн нэгэн гишүүн “энэ сургууль дээр иймэрхүү үйл явдал яаж үүсэн гарч чадаж байна вэ” гэж асуусан/. Оюутны асуудал эрхэлсэн алба бүх оюутнуудад сургуулийн аюулгүй байдлын албанаас бүхий л төрлийн арга хэмжээнүүдийг авч байгаа тухай мэдээлсэн ил захидлыг илгээсэн байна. Оюутны эрүүл мэндийн төвийн зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх албанаас эмхэтгэлдээ дурьдсан бүх төрлийн үйлчилгээгээр дэмжин тусалсан байна. Хэдэн 7 хоногийн өмнө оюутнуудад илгээсэн тэрхүү эмхэтгэлдээ тэр төв нь өөрсдийгөө мэргэжлийн итгэлтэй, нууцыг чандлан хадгалж чадна гэдгээ мэдэгдсэн байв. Оюутны эрх зүйн төв нь анги танхимд хэвийн бус зан үйл гаргаж буй оюутантай хэрхэн харилцах тухай зөвлөгөөг тэнхмүүдэд өгсөн байна. Факультетуудын 7 хоногийн сонин нь болсон үйл явдалтай холбоотойгоор үүсээд байгаа сэтгэл зүйн цочролын дараах айдсын талаар маш түргэн хариулт өгч байх ажилтнууд хэрэгтэй байгаа тухай мэдээлсэн байв. Сургуулийн сонин нэгэн профессорын “би юу ч тохиолдож болох энэхүү орчноос болж бүрэн шокийн байдалд байна” гэсэн хэлсэн үгнээс иш татан бичсэн байв. Оюутнууд болон ажилтнуудын иймэрхүү таагүй байдалд анхаарч сургуулийн цагдаагийн хэсгээс энгийн хувцастай офицерийг ажилтан албан хаагчдыг ажиглаж байхаар сургуулийн гадна талд суулгах арга хэмжээ авсан байна. Код Блуй болсон явдлын дараах 10 хоногийн турш онцгой байдлын утсыг ажиллуулсан байна...

Оюутнууд болон эцэг эхчүүд энэ арга хэмжээнд хариулт өгсөн ба 25 эцэг эх оюутны эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсэг, оюутны асуудал эрхэлсэн алба руу рүү оюутанд зориулсан ямар ямар үйлчилгээ үзүүлэх гэж байгаа тухай үйл явдлын дараах нэг 7 хоногийн туршид утастаж асуусан байгаа юм. Олон эцэг эхчүүд энэ үйл явдлын тухай мэдээлсэнд хүчтэй цочролын байдалд орсон ба их сургуулиас хариулт өгөхийг маш түргэн хугацаанд шаардаж эхэлсэн юм. Тэд иймэрхүү үйл явдал дахин гаргахгүй байх баталгаа гаргуулахыг хүсэж, тэдгээрийн хүүхдүүд сургуулийн орчинд аюулгүй байдалд байхыг хүсэж байв. Мөн оюутнууд оройн цагаар сургуулийн аюулгүй байдалд анхаарч сайн дураар хамгаалалтад зогсох зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан байна.

Болсон үйл явдал нь хамгаалалтын хэрэгцээг нэмэгдүүлж орон нутгийн бизнесменүүдийн ашгийг өсгөсөн байна. Өөрийгөө хамгаалах сургалтын янз бүрийн зар, хамгаалалтын хэрэгслийн талаарх зар сонингуудад үерлэн орж ирсэн байна. Сургууль хийгээд орон нутгийн клубууд өөрийгөө хамгаалах сургалтыг санал болгосон нь түргэн хугацаанд дүүрч дахин шинэ ангийг нэмж нээсэн байна. Сургуулийн номын дэлгүүрт байсан шүгэл гэх мэт зүйлс маш түргэн борлогдсон байна. Сургуулийн цагдаа өөрийгөө хамгаалах

үүднээс гар буу эзэмших тухай хэд хэдэн оюутнуудын хүсэлтийг хүлээн авсан байна. Худалдаачид салаа утасны худалдааг овжноор нэмэгдүүлсэн байна. Хэдийгээр зарим эрэгтэйчүүд өөрсдийн аюулгүй байдал, өөрсдийгөө хамгаалах үүднээс зарим нэг зүйлсийг худалдан авсан ч, ихэнх наймааг эмэгтэйчүүд хийсэн байжээ. Зарим бүтээгдэхүүнүүдийн үнэ эрэлт нэмэгдсэнтэй холбогдон бараг 40 хувиар өссөн байна. Оюутнуудын яриа хамгаалалтын бүтээгдэхүүнүүдийг худалдан авах тухай төвлөрч байлаа. Тэдгээрийн үнэ нь хэд болох, тэдгээрийн хэрхэн ашиглаж болох, аль хамгийн их хэрэгтэй болох гэх мэтчлэн ярилцаж байсан байна.

Дахин сэргээн хэлэлцэх

Зөвлөхүүдтэй ярилцсан эхний ярилцлагуудын үеэр боловсролын салбар дахь сэтгэл зүйн цочролын асуудлаар мэргэжсэн сэтгэл судлаачид руу хандаж байсан юм. Тэдгээр сэтгэл судлаачид яриандаа “дахин сэргээн хэлэлцэх” тухай дурьдаж байсан юм. Одоо 8 сарын дараагаар бид 10-р сарын үйл явдал нь удаан хугацааны туршид нөлөө үзүүлсэн гэдгийг “дахин сэргээн хэлэлцэх” гэсэн нэр томъёогоор дамжуулан ойлгож эхэлсэн юм.

Тэдгээр сэтгэл судлаачдын тайлбарласнаар өөрсдийн туршлагадаа үндэслэн “дахин сэргээн хэлэлцэх” гэдгийг буутай этгээд сүрдүүлсэн тэрхүү бодит үйл явдлыг дахин авч үзэж, иймэрхүү өөр шинэ үйл явдал гарч магадгүй хэмээн хувийн хамгаалалтаа хангах, айдас, үгүйсгэлийн байдлаа дахин амилуулах зэргээр сэрэмжилсэн байдалд орохыг хэлж байсан юм. Зөвлөгөөг өгөгч ажилтнууд, хүчирхийллийн мэргэжилтнүүд нь нэлээд хугацаа өнгөрсний дараагаар байдал дахин сэргэсэн мэт мэдрэмжийг ажиглаж болно гэж тэмдэглэсэн байв. Жишээлбэл уг үйл явдлын дараах нэг жилийн ойгоор ТВ, сонингоор ахиад иймэрхүү зүйл тохиолдож болзошгүй тухай мэдээлж байх жишээтэй.

10 сарын үйл явдлаас хойш мэдрэмжээ дахин сэргээж байгааг тогтоох нь хэцүү, гэвч 18 орчим жилийн өмнө үүнтэй төстэй хэрэг гарч байсан тухай үнэн бодитой мэдээлэл авснаар уг үйл явдлын дараагаар иймэрхүү үр дагавар гарч болзошгүй болохыг илрүүлсэн юм. Бакалаврын дараах сургалтад сурч буй оюутан гартаа винтов барин сургуулийн байшин луу нэвтэрч тэнхмийн эрхлэгчид халдах гэж оролдсон ажээ. Тэр оюутан хэдэн жилийн өмнө энэ профессорын зааж байсан хичээлд муу дүн авсныхаа өшөөг авах гэж оролдсон юм байна. Энэ халдлага нь хуулийн байгууллагууд түүнийг баривчлах, шүүх, хорьсноос хойш хэдэн жил өнгөрсний дараагаар тэр оюутан хэд хэдэн удаа профессор луу халдах гэж оролдсон ба ажилтнууд профессорын хаана байгааг хэлээгүйгээс түүний үйлдлүүд бүтэлгүйтэж байсан байна. Аз болж нэг удаа ч буудаагүй бөгөөд эцэст нь оюутан өөрөө ойлгож баривчлагдсан байна.

Энэ оюутны онцлон онилоод байсан профессор нь дахин дахин давтагдсан тэр үеүдэд төдийгүй халдагчийг баривчлагдсан хойно нь ч сэтгэл зүйн гүнзгий цочролын байдалд байсан байна. Эрүүгийн шүүн таслах цогц систем нь хойшид ч үргэлжилж байсан сэтгэл зүйн хямралын хохирлыг яаж ч чаддаггүй юм байна гэдэгт тэр итгэсэн байна. Эдгээр өдрүүдэд буутай халдлага болсон тухай мэдээлэх бүрт цочролын байдалд дахин оруулж байв. Тэрээр их сургуулиас мэргэжлийн туслалцаа авахыг аль ч үед санал болгоогүй ба өөрийн санаачлагаар нууц байдлаар зөвлөгөөг авч байсан байна. 18 жил өнгөрсөн ч энэхүү

бичигдээгүй хуулийн дагуу тэрхүү профессорын аюулгүй байдлыг хангах үүднээс тусгайлсан цагийн хуваарийг гаргадаг болсон байна.

Сургуулийн төлөвлөлт

10 сарын үйл явдалд оролцсон оюутнуудтай хойшид явал зохих тухай биечлэн уулзаж ярилцсан сэтгэл судлаачидтай уг ярилцлагын тухай ярилцахад сургуулийн бэлтгэлийг хангах тухай асуудал гарч ирсэн. Буутай халдлага гарсны дараа ямар ямар бүлгүүд хувь хүмүүс хариу үйлдлийг үзүүлж байна гэдэгт анхаарлаа хандуулах зуураа сүүлчийн сэдэв болох сургуулийн төлөвлөгөөг олж авсан юм. Нэгэн зөвлөгч “бид 25-30 хүнийг алуулж болох байсан шүү. Бидэнд хөдөлгөөнт холбоотой болохыг төлөвлөх хэрэгтэй байна. Энэ нь өнөөгийн хүчирхийлэлээр дүүрсэн ертөнцөд сургууль хэвийн үйл ажиллагаагаа явуулан оршиход зайлшгүй хэрэгтэй зүйл байх болно” хэмээн сануулж байв. Энэ нь мөн л уг үйл явдалд хариу үйлдэл үзүүлсэн этгээдүүдтэй ярилцахад тэд ч холбоо харилцааг сайжруулахыг чухалчилж байв. Сургуулийн цагдаагийн нэгэн офицер “бид сургуулийн байшин бүрт бүхэл өдөржингөө байж чадахгүй байна” гэж хэлсэн. Гэвч сургуулийн орчин бүхэлдээ аюулгүй байдлын бэлтгэлийг хангасан байх тухайд цөөн хэдэн хүмүүс л ярьж байсан байна.

Сургууль нь зөвхөн бөмбөг дэлбэрэх, гал түймэр, газар хөдлөлт, гэрэл цахилгаан, химийн бодис, цацраг идэвхэт бодис алдагдах, хар сахиx, аюултай бодис, материал алдагдах, цасан шуурга болох, халдварт өвчин дэгдэх гэх мэт аюул осол, гамшигтай холбогдох төлөвлөгөөтэй, харин буут халдлагатай холбогдох ямар нэгэн төлөвлөгөө байсангүй нь сонин байв. Мөн бид сургуулийн зарим нэгжүүд 10 сарын үйл явдлын үеэр яаралтайгаар тогтоолууд гаргасныг олж харсан юм. Жишээлбэл цагдаагийн хэсэг тусгай горимыг боловсруулсан байсан ба түүнийгээ буутай этгээд болон тэр үйл явдалд голлон оролцсон оюутнуудтай холбогдуулан ашигласан байна. Ажил эрхлэлтийн талаар дэмжих хөтөлбөрийн зөвлөх багш, ажилтан нартай юу хийх талаар ярилцсан байна, Оюутны эрүүл мэндийн зөвлөх уг үйл явдал болсны дараагаар ангиудаар явж оюутнуудтай 2 удаа уулзаж ярилцахдаа богино хугацааны үйл ажиллагаа явуулсан байна. Бид сургуулийн төлөвлөгөө юунаас бүрдвэл зохих, энэ нь хэрхэн боловсрогдож, хэрхэн үнэлэх вэ гэдэг асуудлыг дэвшүүлсэн юм.

Хүснэгт 2-т энэхүү тохиолдлын үед гарсан үйл явдлууд, бид төлөвлөгөөтэй холбогдох үндсэн асуултуудыг багтаасан ба мөн сэтгэл зүйн цочролын дараах стресс, гамшгийн тухай ном бүтээлүүдийг бас тусгасан /сургуулийн номнуудад тулгуурлан жагсаалтыг гаргасан, Поланд, Питчер нарыг харна уу (21)/.

Хүснэгт 2. Тохиолдлын үед гарсан үйл явдлууд, сургуулийн төлөвлөгөөтэй холбогдох асуултууд, ном зүй

Тохиолдлын үед гарсан үйл явдлууд	Сургуулийн төлөвлөгөөтэй холбогдох асуултууд	Ном зүй
Зөвлөхүүд сургуулийн төлөвлөгөө гаргах	Яагаад төлөвлөгөөг боловсруулах	Walker (1990), Bird et al (1991)

хэрэгцээ байгааг дэвшүүлэв	шаардлагатай байна вэ	
Тухайн үйл явдалд янз бүрийн бүлгүүдийн олон талт хариу үйлдлүүд	Төлөвлөгөөг боловсруулах ажилд хэн оролцох вэ	Roark & Roark (1987), Walker (1990)
Нэгж дотор үйл ажиллагаа явуулах удирдлагын систем үүссэн	Нэг оффисийн хүрээний ажлыг зохицуулах удирдлагын систем байх ёстой юу	Roark & Roark (1987)
Зарим нэгжүүд дотооддоо тогтоол гарган үйл ажиллагаа явуулсан	Сургуулийн нэгжүүд өөрсдийн тогтоол гарган ажиллахыг нь зөвшөөрөх ёстой юу	Roark & Roark (1987),
Оюутнуудын хариу үйлдлүүдтэй холбогдох асуултууд нэмэгдсэн	Төлөвлөгөөнд хүяирхийлэлийн ямар ямар төрлийг багтаан тусгах вэ	Roark & Roark (1987), Jones (1990)
Бүлгүүд, хувь хүмүүс бидний ярилцлагын үеэр өөрсдийн байдлаа илэрхийлсэн	Болсон үйл явдалд ямар ямар байдлаар хариу үйлдлүүдийг үзүүлсэн байна вэ	Walker (1990), Bromet (1990)
Төв захиргаа, цагдаагийн хэсгээс зөвлөмж/сануулга гарсан	Иймэрхүү үйл явдлаас хамгаалах дунд түвшний аюулгүй байдлыг хангахын тулд юу юу хийсэн бэ	Roark & Roark (1987),
Болсон үий явдлын дараагаар сургуулийн орчин тойрон өөрчлөгдсөн	Аюулгүй байдлыг хангахын тулд Физик орчин ямар байвал зохих вэ	Poland & Pitcher (1990)
Төв захиргаанаас гаргасан зөвлөмж/сануулга	Олон нийт /хэвлэл, бизнес/ болсон үйл явдлыг хэрхэн цэгнэн дүгнэж байна вэ	Bromet (1990), Mitchell (1983)
Сэтгэл зүйн цочролын ба зөвлөгчдөөс гаргасан асуудлууд	Хохирогчдын хувьд сэтгэл зүйн үйл явдлуудаас ямар ямар үр дагавар гарч болох вэ	Zelikoff (1987)
Оюутны эрүүл мэндийн төвийн зөвлөгчдийн ашигласан горим	Уг болсон явдал нь удаан хугацааны туршид хохирогчдод нөлөөтэй юу	Mitchell (1983), Walker (1990)

Сургуулийн төлөвлөгөөний үндсэн элементэд нэгж хоорондын холбоо харилцааг нэмэгдүүлэх тухайд, тэрхүү баримт бичгийг боловсруулахад хэн хэн оролцох, түүнийг хэрхэн зохицуулах, түүнийг ажиллах хүчийг хэрхэн хангах, ямар тусгай горимыг дагуу

ажиллах зэрэг нь багтаж байх юм. Энэхүү горим нь дундаж түвшний хямралд хариу өгөх, гадны бүлгүүдтэй холбоотойгоор сургуулийн аюулгүй байдлыг тогтоох, хохирогчдод сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх зэргийг багтаасан байх юм.

Хэлэлцүүлэг

Үгүйсгэл буюу няцаалт, айдас, хамгаалалт, дахин аюул дэгдэх вий гэсэн зовинол, сургуулийн төлөвлөгөөг боловсруулах гэсэн сэдвүүдийг байгууллагын, сэтгэл зүйн буюу нийгэм-сэтгэл зүйн гэсэн 2 категорид хувааж болох юм. Зохион байгуулалтын хувьд харилцаа холбоо, нэгж хоорондын сул холбоотой байгаад үзүүлж буй хариу үйлдлүүд багтана. Удирдлага, харилцаа холбоо, нэр хүндийн асуудлууд нь кейс стадиг хийх явцад тодорсон юм. Оюутнууд, ажилтнуудынхаа аюулгүй байр болгох үүднээс сургуулийн орчинг өөрчилсөн. Үүссэн хямралд хариу арга хэмжээ авах нэгжүүдийн бие даасан үйл ажиллагаанууд хэрэгжих үед нэгдсэн төлөвлөлт хэрэгтэй байгаа нь дэвшигдсэн, ийнхүү нэгж хооронд зохицуулалт хийх, тэгдгээрийн хамтын ажиллагаа дэмжих зохион байгуулалтын хариу үйлдлүүд хийгдсэн тул ийнхүү нэрлэгдсэн байна.

Шерилл /27/ бидний судалж буй жишээний нэг үйл явдлыг сонгон аваад хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх сургуулийн хариу үйлдлийн загварыг боловсруулсан. Шериллийн тэмдэглэснээр буруутны эсрэг сахилга дэг журмын шинжтэй үйлдлүүд, хохирогчдод зөвлөгөө өгөх бүлэг, биеэ хамгаалах боловсролын хэрэглээ зэргийг нэрлэсэн ба энэ нь бидний кейсэд бүгд илэрсэн билээ. Шерилл олж тогтоосон хариултуудаа бидний мэдээлэл өгөгчдөөр хэлэлцүүлээгүй, үйл явдалд анхлан холбогдсон хүмүүстэй холбогдуулан горимоо боловсруулсан.

Зохион байгуулалтын шинжтэй хариу үйлдлүүдийн тухай ном бүтээлүүдийг уншиж танилцсны дараагаар бидний хүлээж байсан асуудлууд илрэн гараагүй юм. Нэгэн жижиг сургуулийн захиргааны хариу үйлдлийг бичсэн сонингийн мэдээллээс /гол нь буутай эрийг онцлон анхаарсан/ өөр зүйлийг олж чадаагүй байна. Таагүй зүйл болон аюул, осол, гамшигт өртсөн хүмүүст туслах сэтгэлийн цочролын мэргэжилтнүүдийн багийг бэлтгэх тухай Улсын эрүүл мэндийн алба руу хүсэлт гаргаснаас өөр иймэрхүү үйл явдал тохиоход туслах, зөвлөх агентлагтай албан ёсоор холбоо тогтоосон тухай мэдээлэл өөр гарсангүй. Мөн хямралын нөхцлөөс шууд шаардаж байсан хямралын үеийн зохицуулах зохицуулагч, хүлээн авч үйлчлэх төв байгуулж байгаа тухай сонсоогүй болно.

Сэтгэл зүйн буюу нийгэм-сэтгэл зүйн түвшинд болсон үйл явдалд шууд оролцсон оюутнууд хийгээд шууд бус байдлаар холбогдсон оюутнууд, ажилтан нарын сэтгэл зүйн хэрэгцээтэй холбогдсон хариу үйлдлүүд багтаж байгаа юм. Энэ нь зөвхөн сэтгэл зүйн үгүйсгэл, айдас, дахин тохиох бий гэсэн зовинол гэсэн сэтгэл зүйн хариу үйлдлүүдээс гадна хүйс, соёлын бүлгүүдийн асуудлуудыг бид авч үзсэн юм. Эдгээр нь бидний гол сэдвүүдийн анализад хангалттай анхааран судлагдаагүй. Хүчирхийлэлт зан үйл нь бидний соёлын хувьд хүлээн зөвшөөрөгддөг тухай баталгааг ном бүтээлүүдээс олссоны эсрэгээр судалгааныхаа явцад мэдээлэл өгөгчдөөс сургууль дээр хүчирхийлэл гарах нь нэмэгдэж байгаагаас айж байгааг олж мэдсэн байна.

Хэдийгээр бид эрх мэдэлтэй хүмүүс болсон үйл явдалтай холбогдон ухаан санаа нь балартсан багш, оюутнуудын талаар ямар нэг юм хийх байх гэж бодсон боловч сургуулийн эрдмийн зөвлөл болсон үйл явдалтай холбогдуулан юу ч хийгээгүй нам гүм байлаа. Зарим мэдээлэл өгөгчид тэдгээр хүмүүс нь уг зүйлд анхаарал тавихгүйгээс идэвхгүй байна, зарим нь тэд уг асуудлын талаар сайн мэдэхгүй болохоор идэвхгүй ямар нэг зүйл хийж чадахгүй байна хэмээн ярилцаж байв. Бид оюутнуудаас сэтгэл зүйн цочролын дараагаар амгалан тайван болж, хэвийн үйл ажиллагаагаа явуулж, хэвийн байдалдаа хэрхэн орох тухай сонсож чадаагүй. Хэдийгээр жендер болон арьстны бүлгүүдийн асуудал нь эхний ярилцлагуудад хөндөгдөж байсан боловч уг асуудлуудтай шууд холбоотой зүйлсийг олж тогтоож чадаагүй. Брометийн санал болгосноор янз бүрийн бүлгүүдийн хүн амын нийгэм-соёлын хэрэгцээ нь сэтгэл зүйн цочролын хариу үйлдлийг үнэлэн ач холбогдол өгөх байдлаараа ялгагддаг. Бид оюутны эрүүл мэндийн төв дээр зөвлөгөө авахаар хайж ирсэн анхны оюутан эмэгтэй байсныг сонссон. Магадгүй бидний энэхүү тохиолдол ганцхан байсан байж болох юм. Хэдийгээр сэтгэл зүйчид хэн нэгэн алагдаагүй ч гэсэн алагдсан тохиолдлынхтой адил хэмжээний цочролд оруулдаг гэж хэлдэг ч бид тэр үйл явдлын үеэр хэн нэгэн үхсэн /нэлээд хэдэн хүн алагдсан/ бол ямархуу хариу үйлдлийг үзүүлэх байсныг мэдэхгүй байна. Хэдийгээр сэдвийн хувьд ерөнхийлөн дүгнэх боломж байгаа ч, энэхүү кейс стадийн хувьд ерөнхийлөн дүгнэх боломж хязгаарлагдмал байна. Мөн бид болсон үйл явдалд оролцсон бүх оюутнуудтай уулзаж ярилцаагүй, тэдгээрийн сэтгэц заслын үйл ажиллаганд нь хөндлөнгөөс оролцох боломжгүй байсан.

Эдгээр хязгаарлагдмал байдлуудыг үл харгалзан хүчирхийлэлийн үйл явдалд үзүүлэх сургуулийн хариу үйлдлүүдийг холбогдох ном бүтээлүүдэд тулгуурлан нарийвчлан тогтоосж чадсан. Хариу үйлдлийн шинжтэй үйл явцуудын үеэр үүссэн үйл явдлууд нь дараагийн судалгаанд шүүмжлэлт байдлаар дэвшигдэв. Хохирогчдын хариу үйлдэл, мэдээллийн хэрэгслээр түгсэн мэдээлэл, богино хугацааны арга хэмжээнүүд, сургуулийн өөрчлөлтийг судлах, сургуулийн төлөвлөгөөний үнэлгээний судалгааг явуулж болох юм. Буутай халдлага сургууль дээр гарсан хүчирхийлэлийн шинжтэй үйл явдалтай холбоотой бүтээлүүд бараг байхгүй байсан тул уг судалгаа нь үүнтэй төстэй сэдэвт судалгаануудын шинэ суурь үндэс, дараагийн кейсээр шалгагдах онолын баримтлалуудыг эвдсэн судалгаа болсон юм. Практик энэ нь сургуулийн захиргааныхан сургууль дээр гарч болох хүчирхийлэлтэй холбогдон төлөвлөгөөг боловсруулахдаа түүнийг харгалзан үзэх юм. Ер нь уг судалгаа нь тус төлөвлөгөөг боловсруулахтай холбогдон дэвшигдсэн асуудлуудад хариу олоход чиглэсэн билээ. Энэхүү буутай халдлагад өртсөн хүмүүсийн янз бүрийн бүлгүүдийн олонхи нь сургуулийн хямралт төлөв байдалд үзүүлж буй хариу үйлдлүүдийг цогц байдлаар илтгэж байгаа ба иймэрхүү зүйл тохиолдож болзошгүйд бэлтгэлтэй, сонор сэрэмжтэй байх хэрэгтэйг харуулсан юм.

Төгсгөл

Бид энэхүү судалгааг явуулж байх үедээ хэрэв хэн нэгэн алагдсан бол бид яах байсан бол хэмээн мэдээлэл өгөгчдөө үнэлэн өөрсдөөсөө асууж байлаа. Бид энэхүү судалгаанд оролцсон нь ихээхэн аз завшаантай хэрэг байсан юм. Бидний нэг энэхүү туршлага, чадвар дээрээ тулгуурлан ажил эрхлэх болсон. Нөгөө нь Иовагийн Их сургуулийн оюутан байсан ба энэ судалгаанаас олж авсан туршлага нь 1992 оны үүнтэй төстэй үйл хэргийн дэргэд

бас аваачсан байна. Энэхүү туршлага нь сургуулийн анхны төлөвлөгөөн дэх сургуулийн хариу үйлдэл, айдас, үгүйсгэл шиг сэтгэл зүйн хариу үйлдлийг илэрхийлсэн бидний судалгааны туршлага нь бидний үнэлгээнд нөлөөлсөн юм. Тус үйл явдал болсны дараах нэг жилийн ойгоор тиймэрхүү зүйл болоогүй ч, түүний талаар сургуулийн сонинд ямар нэг мэдээлэл бичсэн байв. Буугаар халдлага хийсэн этгээдийн хувьд шоронд тайван сууж шүүх үйл ажиллагаагаа хүлээж байгаа эсэх, түүнийг чөлөөлсөн тохиолдолд биднийг энэхүү кейс судалгаа хийлээ гээд өш санаж заналхийлэх, мөн зарим оюутнуудыг тэр заналхийлэх болов уу гэдгийг мэдэхийг хүсэж байна.